*....... оны ...... сарын ........ өдрийн Хоршооны тэргүүлэгчдийн хурлын .... тоот тогтоолоор батлав.*

**Хоршооны гишүүд, тэргүүлэгчдийн манлайллыг дүгнэх, мэдээлэх журам**

Хоршооны үйл ажиллагаа нь удирдлага, тэргүүлэгчдийн хамтын удирдлагын зөв менежмент, гишүүдийн идэвхтэй оролцоонд тулгуурлан явагдах ба амжилт нь ч тэдгээрээс хамаарах нь ойлгомжтой.

Хоршооны хувьд “тэргүүлэгчид” хэмээсэн нь бусад хуулийн этгээдээс ялгаатай бөгөөд удирдах, даргалах гэхээсээ илүүтэй бусад гишүүдээ тэргүүлэн манлайлах байдлаар хоршооны гишүүдийг идэвхжүүлнэ гэсэн утгатай гэж ойлгож болно.

Хоршоо нь тэргүүлэгчид, гишүүдийнхээ идэвх, оролцоог хагас жил, жилээр дүгнэж байр эзлүүлэн идэвхжүүлэх арга хэмжээг тогтмол авч байна.

Манлайллыг дүгнэх, гишүүдэд мэдээлэх ажлыг хоршооны тэргүүлэгчид, хяналтын зөвлөл хамтран зохион байгуулж байна.

Хоршооны тэргүүлэгчид, гишүүдийн манлайллыг дүгнэх үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Тэргүүлэгчдийн хувьд:

- БГХ-д оролцсон байдал
- Тэргүүлэгчдийн хуралд оролцсон байдал(ирц, оролцоо)
- Хариуцсан хуваарьт ажлын биелэлт, үр дүн
- Хоршоог төлөөлж ажил, үүрэг гүйцэтгэсэн байдал
- Хоршооноос зохиосон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан, түүнд оролцсон байдал
- Гишүүдийн санал бодлыг сонсож, тэдэнд мэдээлэл хүргэж солилцсон байдал
- БГХ, тэргүүлэгчдийн хурлаас шийдвэрийг хэрэгжүүлж буй байдал
- Гишүүний үүргээ биелүүлсэн байдал
- Гишүүд, иргэдийн дундах нэр хүнд, үлгэрлэл
- Хувийн болон өрхийн соёл

Хоршооны гишүүний хувьд:

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн түвшин
- БГХ-д оролцсон байдал(ирц, оролцоо)
- Гишүүний үүргээ биелүүлсэн байдал
- Хоршоотой байгуулсан гэрээний үүргийн биелэлт
- Хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцож дэмжлэг үзүүлсэн байдал
- Хоршооноос зохиосон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцсон байдал
- Хүн ам, иргэдийн дундах нэр хүнд, үлгэрлэл
- Хувийн болон өрхийн соёл

Хоршооны гишүүд, тэргүүлэгчдийн манлайллыг хүн нэгбүрээр гаргаж, хагас болон бүтэн жилийн байдлаар жагсаан тусгай бүртгэл хөтөлж, мэдээллийн самбарт тогтмол байлган хоршооны БГХ болон бусад арга хэмжээний үед тогмол танилцуулж байна.

Хоршоо нь “Оны манлайлагч гишүүн”, “Оны манлайлагч тэргүүлэгч”-ийг жил бүр тодруулж “Манлайлагчийн гэрчилгээ(батламж)”-ийг зохих урамшуулал гардуулан алдаршуулж байна.

Гурав ба түүнээс дээш удаа манлайлагч болсон гишүүнийг хоршооны хүндэтгэлийн дэвтэрт бичиж алдаршуулах, хоршооны зардлаар гадаад, дотоодын аялуулах арга хэмжээг зохион байгуулна.

Манлайллын хувьд хангалтгүй байж хоцрогдргсдод шаардлага, сануулга өгч ажиллана.

Манлайллын үнэлгээний хүснэгт нь дараах загвартай байна.

***Хоршооны тэргүүлэгчийн хувьд:***

| Д\д | Тэргүүлэгч гишүүний овог, нэр | БГХ-д оролцсон байдал | Тэргүүлэгч-дийн хуралд оролцсон байдал | Хариуцсан хуваарьт ажлын биелэлт, үр дүн | Хоршоог төлөөлж ажил, үүрэг гүйцэтгэсэн байдал | Нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан, түүнд оролцсон байдал | Гишүүдийн санал бодлыг сонсож, тэдэнд мэдээлэл хүргэж солилцсон байдал | БГХ, тэргүүлэгчдийн хурлаас шийдвэрийг хэрэгжүүлж буй байдал | Гишүүний үүргээ биелүүлсэн байдал | Гишүүд, иргэдийн дундах нэр хүнд, үлгэрлэл | Хувийн болон өрхийн соёл | Эзэлсэн байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | |

***Хоршооны гишүүдийн хувьд:***

| Д\д | Гишүүний овог, нэр | Хувь нийлүүлсэн хөрөнгийн түвшин | БГХ-д оролцсон байдал(ирц, оролцоо) | Гишүүний үүргээ биелүүлсэн байдал | Хоршоотой байгуулсан гэрээний үүргийн биелэлт | Хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцож | Хоршооноос зохиосон нийтийг хамарсан арга | Хүн ам, иргэдийн дундах нэр хүнд, үлгэрлэл | Хувийн болон өрхийн соёл | Эзэлсэн байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | дэмжлэг үзүүлсэн байдал | хэмжээнд оролцсон байдал | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | |